



## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 03 сарын 25 өдөр

Дугаар А/92

Улаанбаатар хот


### Барилга хүлээлцэх ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дах хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 16 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/184 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Үндэсний Оюу” хоршооны 272,000,000 /хоёр зуун далан хоёр сая/ төгрөгийн үнэлгээтэй 3 орон сууц, Сонгинохайрхан дүүргийн 14 дүгээр хороо, Залуусын гудамжинд байрлах 3 давхар албадан буулгасан барилгын төлбөрт дүйцэх Сүхбаатар дүүргийн 10, 11 дүгээр хорооны хуучин өрхийн эрүүл мэндийн төвийн одоогоор ашиглалтгүй байгаа 2 барилгыг “Үндэсний Оюу” хоршоо, Баянзүрх дүүргийн 15 дугаар хороо, 13 дугаар хороолол, 5 дугаар байрны 148 тоотод оршин суух иргэн Баасанжавын Төмөр-Очирт актаар хүлээлгэж өгөх ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.


2. Дээрх ажлыг хууль, журмын хүрээнд зохион байгуулж гүйцэтгэлийг 2019 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр танилцуулахыг ажлын хэсэг /Н.Раднаасэд/-т, шилжиж буй барилгыг холбогдох журмын дагуу данс бүртгэлээсээ хасахыг ерөнхий нягтлан бодогч /Н.Уранчимэг/-т зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг өмчийн хяналт, шинжилгээ-үнэлгээний хэлтэс /Ч.Ням-Оюун/-т үүрэг болгосугай.

ДАРГА  Ч.ОДНАСАН  
ТТА-2371

115050009227

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын  
даргын 2019 оны 03 дугаар сарын  
25 өдрийн А/Д дугаар тушаалын хавсралт



Ажлын хэсгийн ахлагч:

Өмчийн хяналт, шинжилгээ- үнэлгээний  
хэлтсийн ахлах мэргэжилтэн

Н.Раднаасэд

Гишүүд:

Нийслэлийн Засаг даргын тамгын газрын  
Хуулийн хэлтсийн мэргэжилтэн

.....

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны  
Захиргаа санхүүгийн хэлтсийн орон сууцны  
өргөдөл хариуцсан мэргэжилтэн

Д.Шийтэр

Нарийн бичиг:

Захиргаа санхүүгийн хэлтсийн нярав

Д.Батбаяр